

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МӨСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/35/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ТБОНӨХБАҮХАТ	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
ЗДТГ	<i>Засаг даргын дамгын газар</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
БҮТЭЗ	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МӨСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛМАА ТАНАА

2021-01-24 № 1/01
танай _____-ны № _____-Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.СОЁЛМАА ТАНАА



121070068

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,242,961.00	20,512,841.00
33	АВЛАГА	4,395,000	7,310,000
335	Бусад авлага	4,395,000	7,310,000
3351	Байгууллагаас авах авлага	4,395,000	7,310,000
35	БАРАА МАТЕРИАЛ	14,847,961	13,202,841
354	Хангамжийн материал	14,597,961	12,952,841
35410	Бичиг хэргийн материал	468,610	712,950
35420	Аж ахуйн материал	3,412,737	6,022,727
35430	Сэлбэг хэрэгсэл	1,432,000	185,500
35440	Түлш, шатах тослох материал	6,359,414	3,999,814
35450	Барилгын засварын материал	1,700,200	800,350
35470	Бусад хангамжийн материал	1,225,000	1,231,500
35600	Мал амьтад	250,000	250,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,236,869,044.36	1,319,124,374.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,236,869,044.36	1,319,124,374.96
392	Биет хөрөнгө	1,123,080,266.58	1,205,503,374.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,412,640,635.37	1,583,664,367.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	382,071,881.04	466,305,818.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	106,020,950	100,630,950
39204	Хуримтлагдсан элэгдэл	54,108,481.25	57,026,808
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,384,605	89,799,148
39206	Хуримтлагдсан элэгдэл	72,492,359.17	73,116,223.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,298,143	54,522,274
39208	Хуримтлагдсан элэгдэл	30,591,345.33	26,664,514
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,559,500	2,559,500
39212	Хуримтлагдсан элэгдэл	2,559,500	2,559,500
393	Биет бус хөрөнгө	113,788,777.78	113,621,000
39301	Программ хангамж	2,714,000	2,714,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,207,222	1,375,000
39303	Бусад биет бус хөрөнгө	112,282,000	112,282,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,256,112,005.36	1,339,637,215.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	203,250	4,500,000
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	203,250	4,500,000
413	Өглөг	203,250	4,500,000
4136	Бусад өглөг	203,250	4,500,000
41361	Байгууллагад төлөх өглөг	203,250	4,500,000
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,255,908,755.36	1,335,137,215.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,255,908,755.36	1,335,137,215.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	695,532,945	695,532,945
51101	Өмч: - төрийн	695,532,945	695,532,945
512	Хуримтлагдсан үр дүн	(99,639,713.76)	(15,510,227.86)
51210	Өмнөх үеийн үр дүн	(99,639,713.76)	(94,738,688.46)
51220	Тайлант үеийн үр дүн	-	79,228,460.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	660,015,524.12	655,114,498.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,256,112,005.36	1,339,637,215.96

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	537,771,706	629,865,996
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,016,705	169,077,883
120	Нийтлэг татварын бус орлого	60,016,705	169,077,883
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,016,705	169,077,883
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,079,500	444,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,000	205,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,732,205	168,428,383
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,755,001	460,788,113
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,972,601	64,032,313
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,504,000	4,383,832
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,253,944	55,248,481
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,214,657	4,400,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,782,400	396,755,800
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,342,200	380,495,800
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	29,440,200	16,260,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	495,328,024.94	538,332,956.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,328,024.94	538,332,956.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,671,124.94	524,583,255.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,542,922.79	243,392,251.32
210101	Үндсэн цалин	140,237,605.57	157,914,898.36
210102	Нэмэгдэл	41,270,517.22	47,291,557.76
210105	Гэрээт ажлын хөлс	33,034,800	38,185,795.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,955,573.89	32,732,051.68
210201	Тэтгэврийн даатгал	18,367,489.77	23,091,151.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,147,021.03	2,421,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,616.81	1,935,300
210204	Ажилгүйдлийн даатгал	429,404.22	441,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,294,042.06	4,842,900
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,736,300	22,884,900
210301	Гэрэл, цахилгаан	3,726,200	3,745,300
210302	Түлш, халаалт	15,010,100	19,139,600
2104	Хангамж, бараа материалын зардал	22,363,210	24,346,295
210401	Бичиг хэрэг	2,478,500	4,295,160
210402	Тээвэр, шатахуун	16,350,810	17,105,135
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,533,900	2,946,000
2105	Нормативт зардал	402,000	233,400
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000	233,400
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,237,300	5,641,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000	170,000
210604	Урсгал засвар	6,037,300	5,471,000
2107	Томилолт, зочны зардал	9,327,400	2,380,000

210702	Дотоод албан томилолт	9,327,400.00	2,380,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,425,450	24,403,434
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,475,450	23,268,036
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000	260,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000	323,961
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	30,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000	400,000
210807	Газрын төлбөр	138,000	121,437
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,680,968.26	168,569,923.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,515,771	59,300,569
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,165,197.26	109,269,354.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,656,900	13,749,701
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,977,400	11,965,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,622,4000	11,695,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	355,000	270,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	679,500	1,784,001
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	679,500	1,784,001
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	42,443,681.06	91,533,039.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,734,797.22	12,304,579.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,734,797.22	12,304,579.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33,734,797.22)	(12,304,579.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,708,883.84	79,228,460.60

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	479,039,501	461,437,613
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,284,500	649,500
120	Нийтлэг татварын бус орлого	1,284,500	649,500
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,284,500	649,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,079,500	444,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,000	205,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,755,001	460,788,113
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,972,601	64,032,313
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,504,000	4,383,832
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,253,944	55,248,481
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,214,657	4,400,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,782,400	396,755,800
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	349,342,200	380,495,800
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	29,440,200	16,260,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	392,906,071	426,036,732

21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,906,071	426,036,732
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,934,171	404,977,031
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,617,100	242,307,148.32
210101	Үндсэн цалин	140,417,600	157,914,898.36
210102	Нэмэгдэл	41,164,700	47,291,557.76
210105	Гэрээт ажлын хөлс	33,034,800	37,100,692.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,827,100	32,732,051.68
210201	Тэтгэврийн даатгал	18,242,500	23,091,151.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,146,100	2,421,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,000	1,935,300
210204	Ажилгүйдлийн даатгал	429,200	441,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,292,300	4,842,900
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,438,300	21,651,400
210301	Гэрэл, цахилгаан	3,726,200	3,999,200
210302	Түлш, халаалт	17,712,100	17,652,200
2104	Хангамж, бараа материалын зардал	21,437,700	23,749,855
210401	Бичиг хэрэг	3,199,000	3,199,000
210402	Тээвэр, шатахуун	14,794,800	17,106,955
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900	3,443,900
2105	Нормативт зардал	402,000	382,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000	382,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,637,200	10,910,100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000	200,000
210604	Урсгал засвар	6,437,200	10,710,100
2107	Томилолт, зочны зардал	9,327,400	2,260,000
210702	Дотоод албан томилолт	9,327,400	2,260,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,795,200	24,779,776
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,845,200	23,592,776
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000	260,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000	275,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	30,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000	475,000
210807	Газрын төлбөр	138,000	147,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,452,171	46,204,700
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,452,171	46,204,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,971,900	21,059,701
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,897,400	11,965,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,622,400	11,695,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000	270,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,074,500	9,094,001
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,074,500	9,094,001
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	86,133,430	35,400,881
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	86,133,430	35,400,881
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,133,430	35,400,881
2200	Дотоод эх үүсвэрээр	86,133,430	35,400,881
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	86,133,430	35,400,881

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(86,133,430)	(35,400,881)
---	--	--------------	--------------

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	660,015,524.12	(108,348,597.60)	1,247,199,871.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			8,708,883.84	8,708,883.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532,945	660,015,524.12	(99,639,713.76)	1,255,908,755.36
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	660,015,524.12	(99,639,713.76)	1,255,908,755.36
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	660,015,524.12	(99,639,713.76)	1,255,908,755.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(4,901,025.30)	4,901,025.30	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	(94,738,688.46)	1,255,908,755.36
D08	Тайлант үеийн үр дүн			79,228,460.60	79,228,460.60
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,532,945	655,114,498.82	(15,510,227.86)	1,335,137,215.96

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	379,387,400	379,387,400	397,641,400	395,621,299
21	УРСГАЛ ЗАРДАЛ	379,387,400	379,387,400	397,641,400	395,621,299
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,490,000	356,490,000	385,670,700	383,655,599
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,617,100	214,617,100	242,142,300	241,778,800.32
210101	Үндсэн цалин	140,417,600	140,417,600	157,914,900	157,914,898.36
210102	Нэмэгдэл	41,164,700	41,164,700	47,352,600	47,291,557.76
210104	Урамшуулал	33,034,800	33,034,800	36,874,800	36,572,344.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,827,100	26,827,100	32,689,300	32,644,498.68
210201	Тэтгэврийн даатгал	18,242,500	18,242,500	23,003,600	23,003,598.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,146,100	2,146,100	2,421,400	2,421,400
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,000	1,717,000	1,937,100	1,935,300
210204	Ажилгүйдлийн даатгал	429,200	429,200	484,300	441,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,292,300	4,292,300	4,842,900	4,842,900
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,438,300	21,438,300	21,651,400	21,651,400
210301	Гэрэл, цахилгаан	3,726,200	3,726,200	3,999,200	3,999,200
210302	Түлш, халаалт	17,712,100	17,712,100	17,652,200	17,652,200
2104	Хангамж, бараа материалын зардал	22,937,700	22,937,700	23,339,800	23,339,800

210401	Бичиг хэрэг	3,199,000	3,199,000	3,199,000	3,199,000
210402	Тээвэр, шатахуун	14,794,800	14,794,800	16,696,900	16,696,900
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900	3,443,900	3,443,900	3,443,900
2105	Нормативт зардал	402,000	402,000	402,000	382,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000	402,000	402,000	382,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,637,200	3,637,200	1,929,000	1,929,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000	200,000	200,000	200,000
210604	Урсгал засвар	3,437,200	3,437,200	1,729,000	1,729,000
2107	Томилолт, зочны зардал	9,327,400	9,327,400	2,940,400	2,140,000
210702	Дотоод албан томилолт	9,327,400	9,327,400	2,940,400	2,140,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,295,200	33,295,200	21,918,700	21,132,300
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,345,200	32,345,200	20,731,700	19,945,300
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000	260,000	260,000	260,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000	275,000	275,000	275,000
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000	30,000	30,000	30,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000	247,000	475,000	475,000
210807	Газрын төлбөр	138,000	138,000	147,000	147,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,008,000	24,008,000	38,657,800	38,657,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,008,000	24,008,000	38,657,800	38,657,800
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,897,400	22,897,400	11,970,700	11,965,700
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,897,400	22,897,400	11,970,700	11,965,700
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,622,400	22,622,400	11,695,700	11,695,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000	275,000	275,000	270,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	379,387,400	379,387,400	397,641,400	395,621,299
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	378,782,400	378,102,900	397,036,400	394,971,799
131001	Улсын төсвөөс санхүүжих	349,342,200	348,662,700	380,776,400	378,711,799
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	29,440,200	29,440,200	16,260,000	16,260,000
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000	1,284,500	605,000	649,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	1,079,500	400,000	444,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,000	205,000	205,000	205,000
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	28	28
620001	Удирдах ажилтан	8	8	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3	3	3

620004	Гэрээт ажилтан	8	8	8	8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28	28	28
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13	13	13
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	7	7

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,972,601	64,032,313
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,629,071	28,631,432
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,234,071	21,321,432
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		570,300
210105	Гэрээт ажлын хөлс		570,300
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		45,601
210201	Тэтгэврийн даатгал		45,601
2104	Хангамж, бараа материалын зардал		410,055
210402	Тээвэр, шатахуун		410,055
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000	8,981,100
210604	Урсгал засвар	3,000,000	8,981,100
2107	Томилолт, зочны зардал		120,000
210702	Дотоод албан томилолт		120,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,647,476
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,647,476
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,234,071	7,546,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,234,071	7,546,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,395,000	7,310,000
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,395,000	7,310,000
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,395,000	7,310,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,343,530	35,400,881
2200	Дотоод эх үүсвэрээр	82,343,530	35,400,881
221001	Их засвар	82,343,530	
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		35,400,881
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	98,972,601	64,032,313
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,972,601	64,032,313
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,504,000	4,383,832
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,253,944	55,248,481
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,214,657	4,400,000

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Х.Соёлмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын зарцуулалт, төсвийн төлөвлөлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19-нөөс 2021 оны 01 дугаар сарын 23-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ЗДТГазар нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Тухайн шатны хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөст сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй, байна Мөн сумын ЗДТГазар болон Санхүүгийн албанаас дотоод аудитын нэгжгүй, хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2008 онд хийгдсэн хяналт шалгалтаар тавигдсан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тавигдсан төлбөрийг актыг тухайн үед төлж барагдуулаагүйгээс тайлант онд 1152.1 мянган төгрөгийг төлсөн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 245139.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2451.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 629866.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6298.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөст сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83525.2 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	4,395.00	7,310.00	2,915.00
БАРАА МАТЕРИАЛ	14,847.96	13,202.84	(1,645.12)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,236,869.04	1,319,124.37	82,255.33
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,112.01	1,339,637.22	83,525.21
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	203.25	4,500.0	4,296.75
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,255,908.76	1,335,137.22	79,228.46
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,256,112.01	1,339,637.22	83,525.21

Авлага дансны үлдэгдэл 7310.0 мянган төгрөг болж 2915.0 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сургуулийн дотуур байрны засвар хийгдэж гүйцэтгэлийн барьцаа 4500.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой үүссэн бөгөөд энэ авлага бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13202.8 мянган төгрөг болж 1645.0 мянган төгрөгөөр буурсан нь сумын ИТХ-ын 21 тоот тогтоолоор бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг акталснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 250.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаа ч 2018 оны өвлийн зудаар хорогдсон боловч тухайн үед малын эмчийн тодорхойлолт дүгнэлт гаргуулаагүй, өмнө аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1779899.8 мянган төгрөг, оны эцэст 1946172.2 мянган төгрөгөөр болж 166571.2 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтаар 149074.7 мянган төгрөгөөр халуун усны барилга, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Соёмбот цэг” 29894.3 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар тавилга эд хогшил шинэчлэхэд 27149.1 мянган төгрөг, аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсээс 1857.1 мянган

төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авч хөрөнгө нэмэгдсэн байна.

Сум дундын эмнэлэгт 1000.0 мянган төгрөгийн анализаторын аппаратыг үнэ төлбөргүй шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын 104 тоот, сумын ИТХ-ын 21 тоот тогтоолоор 43 нэр төрлийн 36556.9 мянган төгрөгийн акталсан, нийт 37556.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр оны эхэнд 203.2 мянган төгрөг оны эцэст үлдэгдэл 4500.0 мянган төгрөг болж 4296.8 мянган төгрөгөөр өссөн нь уг өр төлбөр нь сургуулийн дотуур байрны дээврийн засвар хийгдэж гүйцэтгэлийн баталгааны үлдэгдлийг оны эцэст нэмэлт дансанд байршуулснаас шалтгаалжээ. Өр төлбөр дансны үлдэгдэл 4500.0 мянган төгрөг нь барагдуулах боломжтой үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 695532.8 мянган төгрөг болж тайлант онд өөрчлөлтгүй байна.

Мөст сумын ЗДТГазрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 108803.5 мянган төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 108803.5 мянган төгрөгийн орлогоос 17973.4 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 127653.3 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн, 34940.3 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 40930.6 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 33509.7 мянган төгрөг буюу 13.9 хувиар, тогтмол зардал 4148.6 мянган төгрөг буюу 22.1 хувиар, хангамж бараа материалын зардал 1983.1 мянган төгрөг буюу 8.9 хувиар өссөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 9818.8 мянган төгрөг буюу 28.7 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 596.3 мянган төгрөг буюу 9.6 хувиар, тэтгэвэрт гарахад нэг удаа удаагийн мөнгөн тэтгэмж 10656.7 мянган төгрөг буюу 52.8 хувиар дээрх зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 4901.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь акталсан хөрөнгөтэй холбоотой 2009 онд дахин үнэлэгдсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397574.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 397574.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 10/05 тоот тогтоолоор ЗДТГазрын 2020 оны төсвийг батлахдаа байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн арга хэмжээний төсвийг батлахдаа зориулалт бусаар зарцуулахаар баталснаас шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 397574.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 380709.7 мянган төгрөгийг

орон нутгийн төсвөөс, 16260.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 380495.8 мянган төгрөг, ОНХС-аас 16260.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 649.5 мянган төгрөг, нийт 397405.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 395621.3 мянган төгрөгийг зарцуулж 1784.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 395621.3 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 408.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 786.4 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 800.4 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 5.0 мянган төгрөг, нормативд зардлыг 20.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 2020.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,373.0
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	220.8
80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	287.5
82212	Хог хаягдал, орчны бохирдол	138.8
	ДҮН	2,020.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн хөрөнгө оруулалтаар сумын халуун усны гаднах цооног хийх, ЗДТГ-ын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шинэчлэхэд 414467.0, түрээсийн орлогоор 1350.0, байгаль орчныг нөхөн сэргээх барьцаанд 2900.0, өмнөх оны авлагаас 3395.0, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 4500.0, статистикийн хэлтсээс судалгааны ажлын зардалд 4673.4 аймгийн Онцгой байдлын газраас 120.0, Ковид-19 цар тахлын санхүүжилт 5646.9 мянган төгрөг нийт 64032.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс орон сууц хүн амын тооллого, хагас жилийн мал тооллогын судалгааны зардалд 4673.4 мянга, Ковид-19 цар тахлын үйл ажиллагаанд 5766.9 мянга, Тамгын газрын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад 30544.0 мянга, халуун усны гаднах цооногийн тохижилтын ажилд 12397.8 мянга, ЗДТГ-ын халаалтын системд урсгал засварт 1440.2 мянга, Баянхайрхан багийн худгийн засварт 1900.0 мянга нийт 56722.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7310.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 156 мэдээлэл, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая

төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг тэтгэвэрт гарахад нэг удаа олгодог мөнгөн тэтгэмж, малын гаралтай бүтээгдэхүүнд шинжилгээ тоног төхөөрөмж худалдан авсан, 12 дугаар сард албан хаагчдад олгосон түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8174.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 52.5 хувьтай байна. Энэ нь сумын ЗДТГ-ын жолооч нь замын хуудсаа бүрэн хүлээлгэн өгч чадаагүй гол шалтгаан нь гэнэт нас барсантай холбоотой байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	8,174.7		4,292.2	1	3,882.5	52.5
Нийт дүн	1	8,174.7	-	4,292.2	1	3,882.5	52.5

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11065.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6376.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4689.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийг 90000.0 мянган төгрөгөөр засвар хийж байгаатай холбоотой гүйцэтгэлийн барьцааны 4500.0 мянган төгрөгийг буцаан өгөхөөр өр үүсгээгүй,
2. Аймгийн болон сумын ИТХ-ын тогтоолоор акталсан хөрөнгийн 2009 онд дахин үнэлгээний нэмэгдлийг 844.5 мянган төгрөгөөр бууруулах бичилтийг дутуу хийсэн,
3. Бараа материалаас 1031.5 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг данс бүртгэлээс хасахдаа шилжүүлсэн гэсэн үзүүлэлтийг сонгосон холбоотой нийт 6376.0 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад хийгдлээ.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 6376.0 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 4689.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онуудад дамжин хэрэгжүүлсэн Мөст сумын Боорж голын 37.8 метр урттай төмөр бетон гүүрийг “Эйч Кэй Би интернэйшнл холдинг” ХХК гүйцэтгэсэн байна.

Аудитын хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яамнаас 776.8 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлд бүртгэх тухай шийдвэр ирүүлсэн байна.

Гэвч гүүрний тулгуурын шонгийн бат бэх чанар муу, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нэг эгнээ урсгалтай, үерийн далангийн хамгаалалт шаардлага хангахгүй чанаргүй хийгдсэн талаар нутгийн удирдлага болон иргэдээс мэдээлэл ирүүлснийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн аудитаар албан шаардлага өгөгдөж хэрэгжилт хангагдаагүй, холбогдох байгууллагаас данс бүртгэлд тусгаагүй талаар албан тоот ирүүлсэн тул анхаарал татахуйц чухал асуудал байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Тайлант онд түлээ, нүүрс худалдан авч зарцуулалтыг тухайн өдөрт хэчнээн хэмжээний түлээ нүүрсийг зарцуулж байгаа тооцоогүй тухайн сард нийт дүнгээр нь зарлагадсан, жолоочийн замын хуудасны анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, спидометрийн эхний болон сүүлчийн заалтыг бичээгүй шатахууны тооцоог бодсон, зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. **Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Өмнөх оны ангийн давсан орлогоос 2020 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг сумын ИТХ-ын 2019 оны 10/05 тоот тогтоолоор батлахдаа сумын стратеги төлөвлөгөө боловсруулах, сургуулийн дотуур байрны эмийн зардал, цаг уурын хашааны үлдэгдэл санхүүжилт олгох зэрэгт зориулалт бусаар 4689.8 мянган төгрөгөөр баталж зарцуулсан байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах,

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Байгалийн нөөц, ашигласны тухай хуулийн 13.1-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө

багтана.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн байгаль хамгаалах санг оновчтой төлөвлөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны дагуу сар бүрийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээ, өмнөх 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.2. Эрсдэл: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “... аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 1 сарын 1-ны дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудыг хэрэгжүүлэн хуульд заасан мэдээллийг олон нийтэд үнэн зөв мэдээлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Мөст сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/35/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мөст сумын Засаг даргын тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд худалдан авсан түлээ, нүүрсний зарцуулалтыг өдөр тутамд зарцуулсныг нотлох баримтгүй, жолоочийн замын хуудсанд спидометрийн эхний болон сүүлчийн заалтыг бичээгүй тооцоо бодсон шатахууны зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй	-	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Х.Соёлмаа Х.Отгонням
2	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг төлөвлөхдөө зориулалт бусаар зарцуулахаар баталсан	4689.8	Зөвлөмж өгөх		

3	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй	-	Зөвлөмж өгөх		
4	Өр төлбөрийг дутуу тусгасан, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бууралтыг дутуу, акталсан бараа материалыг зарлагдахдаа санхүүгийн программд шилжүүлсэн гэж зарлагдсан	6376.0	Залруулга хийх		
ДҮН		11065.8			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР